

Living the Lotus 11

Buddhism in Everyday Life

2023

VOL. 218



Чинкан цамхаг, Тайвань улс,
Тайнан хот дахь түүхэн дурсгалт газар

Rissho Kosei-kai of Tainan

Living the Lotus Vol. 218 (2023.11)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami
-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туульгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Мунхаг сэтгэлийг тогтоон барих тухай

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Ухаан” нь “өвчлөхөд”-д “мунхаг” үүсдэг

Энэ жилийн зун гамшгийн түвшинд хүрхэцүйц онцгой халуун байсан гэлцэх боловч хэт халаагүй байсан ч хүмүүс бид зун болохоор “ямар халуун байна аа”, өвөл болохоор “хөдлөө” гэж гомдоллох дуртай. Ийнхүү байгаль дэлхийн жам ёс болон болоод өнгөрсөн зүйлийн тухай “юм хэлээд ч нэмэргүй зүйл дээр харуусах”-ыг “мунхаглах, муйхарлах” гэж нэрлэдэг. Та бүхэнд “яриад ч өөрчлөгдөхгүй зүйл дээр гомдоллох” гэдгийг сонсоод ямар нэг зүйл санаанд нь бууж байна уу?

Миний хувьд мунхаг 愚痴 хэмээх үгийг бүтээж буй хоёр ханз үсгийн 「痴 хэмээх ханзны сонголт сонирхол татаж байна. Аливаа зүйлийг ойлгож, дүгнэлт хийх чадварыг илэрхийлэх ухаан, түүнийг дэмжих мэдлэгийг 「知」 оюун ухаан хэмээх ханз үсгээр тэмдэглэдэг бол тэрхүү ханз гадуураа 「疒」 өвчин гэдэг ханзаар хүрээлүүлсэн байна.

Хүн төрөлхтөнд аливаа зүйлийг тунгаан бодож, үйлдэл хийх оюун ухаан заяагдсан гэгддэг. Байгалийн шинжлэх ухааны доктор Сажу Харуо хэлэхдээ: Хүн төрөлхтөн нь сансар огторгуйн хаа сайгүй байгаа ус төрөгч, нүүрстөрөгчтэй ижилхэн элементээс бүрэлдэн тогтсон хэрнээ, “өөрөө бодож, өөрөө үйлдэж, бодол санаагаа бусадтай хуваалцаж, харилцан бие биедээ тусалж амьдардаг, гайхалтай онцгой бодьгал” ([14 насны төлөөх цагийн онол])-ийг хүн гэж нэрлэнэ. Хүн төрөлхтөнд “ирээдүй болон өөрөөсөө бусад хүнийг төсөөлөх, таамаглах чадвар” = Сэтгэл байдаг учраас ийм чадвартай болсон гэлцдэг.

Гэтэл бид тэрхүү Сэтгэл гэгч зүйлээрээ амин хувиа хичээсэн шунал болон уур хилэнгээ тэтгээд байвал өөрийгөө болон бусдыг зовоох мунхаглалыг давтаж орхидог. Сэтгэл нь мунхаг хэмээх өвчинд нэрвэгддэг байна. Тэгвэл амин хувиа хичээсэн шунал, уур хилэнг томруулахгүй байхын тулд яавал дээр вэ? Мунхагийн өвчнийг эдгээхийн тулд юу чухал вэ?

Гомдлыг сайн сонсоцгооё

Дээр дурдсан Сажи Харуо докторын үгийг эргэн нэг санацгаая. Хүн төрөлхтөн бусадтай хамтрах, бусдыг бодох, ирээдүйгээ төсөөлөн бодох таамаглах чадвартай учраас түүнийгээ илүү хөгжүүлэн ил гаргах хэрэгтэй. Дураараа сэтгэл гарах гээд байвал аливаа зүйлийг олон талаас нь харах, бусдын байранд өөрийгөө тавьж үзэх хэрэгтэй. Эсвэл “мунхаг нугуудад шүтэн барилдлагын хуулийг сурга” гэж Нирваан сударт бичигдсэн байдаг шиг, өөрийгөө олон зүйлийн ач тусаар амьдарч байгаагаа эргэн санаж, тэр төсөөллөө бататгаад үзээрэй. Ийнхүү багахан ч гэсэн талархсан сэтгэлээр амьдарч чадвал мунхагийн сэтгэл аяндаа багасаад ирнэ.

Шүтэн барилдлага талаас тайлбарлахад гэр бүл дотор эцэг эх нь үргэлж бусдыг муулж, аливаад шүүмжтэй ханддаг бол хүүхдүүдэд нь ч нөлөөлж юм л болвол гомдол хэлэх нь ихэсдэг гэсэн судалгааны үр дүн байдаг гэлцдэг. Эргэн тойрны хүнийхээ мунхаг бухимдлыг төрүүлэх учрал болох уу, билиг оюуныг нь хөгжөөх учрал нь болох уу? Бид ямар сэтгэл тээхээс хамаарч үр дүн нь өөрчлөгдөнө.

Гэхдээ огт гомдол хэлж болохгүй гэхээр хэцүү санагдах байх. Шунал болон уур хилэнд автаж болохгүй боловч урам зориг дутаад гомдол хэлэх нь заримдаа хэрэгтэй ч зүйл байж магадгүй. Энэ нь аажимдаа “хэлээд ч нэмэргүй зүйлд автаж өөрийгөө зовоохоо больё” хэмээн өөрөө анзаарч, тунгаан бодож, сэтгэлээ засаад урагшаагаа явах эхлэл болох үе ч байдаг.

Энэ талаас нь бодохоор бид өөрсдөө хүний хэлэх гомдлыг хүлээн авч, сонсож өгөх сав шиг болох нь чухал гэж бодож байна.

Үргэлж бусдын гомдлыг сонсох нь хэцүү гэх хүн байж магадгүй. Хүний төлөө сэтгэлээр нөгөө хүнийхээ шаналгаж байгаа асуудлыг дуустал нь сонсож, гомдлыг нь тайлах. Ийнхүү “билиг оюуны сэтгэл”-ийг хамтдаа хайх нь бие биенийхээ сэтгэлийн эрүүл мэнд, эрч хүчийг тэтгэхээс гадна хүнийхээ хувьд хөгжих том үүд хаалга болно.

<Косей> 2023 оны 11-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Хуурамч ордон ба эрдэнэсийн тухай үлгэр

Олон хүн эрдэнэсийн эрэлд гарч, алс холын бартаат замыг туулж байв. Гэсэн хэдий ч зарим нь замын дундаас бэрхшээлээс шантран буцдаг. Харин хүмүүсийг хэрхэн удирдан чиглүүлэхийг мэддэг удирдагч нь ид шидийн ордон бий болгож, тэднийг амраангаа эцэст нь эрдэнэс байгаа газарт хүргэж чаджээ.

Урт, бартаат зам бол бидний амьдрал бөгөөд удирдагч нь бурхан багш юм. Амьдралд бууж өгөхөө шахах үед бурхан багш бидэнд янз бүрийн арга /уран арга/ зааж, сургаалын дагуу амьдрахад чиглүүлдэг гэдгийг энэхүү үлгэрт өгүүлжээ.



Бяцхан мэдлэг

Цагаан лянхуа судрын “Хувилгаан балгасаар зүйрлэхүйг өгүүлэх бүлэг”-т гардаг жишээ буюу Бурхан багшийн хамаг амьтныг гэгээрэлд хүргэхийн төлөөх “Амьтай бүхэн Бурханы гэгээрэлд хүрч чадна” хэмээх сургаалыг “Эрдэнэс”-ээр зүйрлэжээ.

Энд өгүүлэх “Бурханы гэгээрлийг олох” гэдэг нь хүн чанарыг төгөлдөржүүлж, жинхэнэ аз жаргалтай амьдралаар амьдрахыг илэрхийлж буй.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Энгэрт оёсон эрдэнэсийн тухай үлгэр



тангараг юм. Найзынх нь эрдэнэсийн тухай хэлсэн явдал бол түүнийг буддагийн зэрэгт хүрэхийг зөвшөөрсөн гэсэн утгыг илэрхийлж буй. Будда болж чадаагүй ч өргөсөн тангараг мартаагүй л бол Бурханы адислалыг хүртэх боломжтой гэдэг.

Бяцхан мэдлэг

Цагаан лянхуа судрын “500 шавь бурханаас иш хүртсэн нь” хэмээх бүлэгт гардаг зүйрлэл буюу найз нь хувцас дотор нь эрдэнэс оёж өгдөг нь бид Бурхан багшийн ачаар тангараг өргөж байна гэсэн утгатай. Дээр өгүүлсэн “Хүлээн зөвшөөрөл” бол биднийг “Будда болж чадна” гэсэн баталгаа юм.

Нэгэн ядуу эр сайн найзынхаа гэрт уригдан хоолоор дайлуулсныхаа дараа унгаж орхижээ.

Найз нь түүний энгэрийн дотор талд эрдэнэс хийж оёчихоод яваад өгдөг. Гэвч ядуу эр эрдэнэсийг анзаараагүй бөгөөд өрөвдөлтэй амьдралаар амьдарсаар байв. Хэдэн жилийн дараа найзтайгаа дахин тааралдахад түүнд эрдэнэсийн талаар хэлжээ. Тэрхүү сайн найз нь Бурхан багш, харин эрдэнэс бол Будда болох

Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК, удаах ерөнхийлөгч
Нивано Коошоо

Хариу нэхээгүй хайр

Хүүхдээ бодох эцэг эхийн хайрыг “хариу нэхээгүй хайр”, “болзолгүй хайр” гэж нэрлэдэг. Үнэхээр эцэг эхчүүд өөрийнхөө тав тухыг хойш нь тавьж, хүүхдээ хөхүүлэх, хичнээн нойр хүрч байсан ч босоод живхийг нь солих, унтах хүртэл нь бүүвэйлэх зэргээр санаа тавьдаг. Хүүхэд нь халуурвал өөрөө өвдсөн байсан ч унталгүй хүүхдээ асардаг.

Тэгсэн хэдий ч энэ нь жинхэнэ “хариу нэхээгүй хайр” мөн үү гэвэл, эргэлзээтэй санагдаж байна. Өдөр бүр өсөн торниж буй хүүхдийнхээ инээмсэглэл, эгдүүтэй үйлдлүүд, “ээжтэйгээ л баймаар байна” хэмээн хэн хүнээс илүү чамайг гэдэг учраас л хүүхэд өсгөх хүнд үеийг бид давж гардаг. Өөрөөр хэлбэл өдөр бүр хүүхдээсээ зөндөө бэлэг авдаг гэж би боддог.

Харин хүүхэд жаахан томроод ирэхэд юм хэлэхээр сонсдог бол сайн хүүхэд, сонсдоггүй бол муу хүүхэд гэж “болзолтой хайр”-аар хүүхэдтэйгээ харилцах гээд байдаг тал бий. Хүүхдийнхээ ачаар эцэг эх болсон хэрнээ, би л өсгөсөн гэж бодох гээд байдаг. Түүнтэй харьцуулахад эцэг эхийгээ гэх хүүхдийн хайр хамаагүй илүү “хариу нэхээгүй хайр” шиг санагддаг. Том охин маань жаахан байхдаа “ээжээ, ээжээ” гээд намайг хайн уйлахыг харсан манай ээж: “Ийм түүхийгээрээ шахуу ээжээс яаж ч бодсон арвин туршлагатай эмээ нь илүү баймаар юм, тэгэхэд ээж л байхгүй бол болохгүй юм байх даа” гэж билээ.

Үүнийг сонссон би жаахан ядрахаараа “ганцаараа баймаар байна” гэж бодон, унтаж өгөхгүй байгаа охиндоо “хурдан унтаач!” гэх зэргээр загначихдаг над шиг ээжийг харин ч охин маань болзолгүй итгэж, хайрлаж, өөрийнхөө амь насыг даатгаж байгаа гэдгийг анзаарч, жижигхэн биедээ тээсэн агуу хайранд сэтгэл хөдөлж билээ.

Энэ жилийн эхэнд болсон явдал. Өглөө үүр цайх үед гэрийнхээ бурханд идээ өргөх гээд доош буух зуураа хүүхдийнхээ өрөөний урдуур явахад улаан өнгийн гэрэл ассан байлаа. Чийгшүүлэгчний ус нь дууссан юм байх даа гэж бодон тэр зүгт харсан чигтээ алхаж байгаад гэнэт хатуу зүйлийг нүүрээрээ очоод мөргөх нь тэр.

Арай хийж, бурхандаа идээ өргөж дуусаад, өвдөхөө огт болихгүй байсан болохоор гэрийнхээ ажлыг ч хийлгүй, буйдан дээр хэвтэж байтал удалгүй хүүхдүүд ч сэрэв. Нэг нэгээрээ ирж хараад “Та чинь яачихаа вэ?” гэж асуух тул би учраа тайлбарлав. Тэгтэл дөрвүүлээ хоорондоо ярьж тохиролцсон шиг “хөөрхий дөө, зүгээр үү?” гээд дэргэд ирээд, мөрнөөс тэвэрч, илж байв. Хэн нь ч “болгоомжтой алхахгүй яасан юм бэ” зэргээр намайг буруутгаагүй ээ.

Харин би хүүхдүүдээ гэмтэж бэртэх үед “аюултай гэж хэлээд байхад” гэж эхлээд буруутгах үгийг хэлдэг байсан өөрийгөө эргэн санаж, жижигхэн гараас нь мэдрэгдэх хайр энэрэлд уяран нулимс унагав. Миний нулимсыг хараад хүүхдүүд “өвдөж байна уу?” хэмээн санаа зовинов. “Үгүй ээ өвдөлтөөс илүүтэй та нарынхаа хайранд уяраад, өөрөө хүүхэд болсон шиг санагдчихлаа”. Тэгтэл том хүн шиг нухацтай царай гарган



Нивано Коошоо

Рисшо Косей Кай байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуульч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараа тус байгууллагын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.


Өдгөө Цагаан Лянхуа Судрыг судлан суралцахын хажуугаар гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтрах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн тус байгууллагын удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

“сайн хүүхэд шүү, зүгээр ээ” гээд миний толгойг илэв.

Хамар доороо гурван оёо тавиулах хэмжээний гэмтэл байсан боловч, өвдөлтөөс илүү хүүхдүүдийн “болзолгүй хайр” ялж, хамар доорх оёоноосоо ичих нь битгий хэл бахархалтай нь аргагүй тэр оройноо гадаадаас ирсэн зочдыг тосч аван, дараагийн өдөр нь ариун ордонд үүрэг гүйцэтгэсэн билээ.

“Якүшин” 2010 оны 11-р сарын дугаараас



Олон улсын хэлтсийн даргын булан

Сонсохын ач холбогдол

Акагава Кэйичи

Та бүхний амгаланг айлтгая. Японд зуны аагим халуун дуусахтай зэрэгцэн модны навчис шаргалтаж эхэллээ. Намрын улирлыг гүн гүнзгий мэдэрч буй эдгээр өдрүүдэд байгаль дэлхийн тасралтгүй хувьслыг бахдан биширч байна.

Энэ сард зовлон шаналлын үндэс болох “Турван хор”-ын сүүлийнх буюу “Мунхаг”-ийн тухай айлдварыг сонслоо. “Нирваан судар”-т “Мунхагт нэрвэгдсэн хүнд шүтэн барилдлагын хуулийг заа” гэж өгүүлсэн байдаг боловч зүрх сэтгэл нь аминчхан шунал хүсэл, уураар багтаж ядсан хүнд шүтэн барилдлага, учир шалтгааны хуулийг хичнээн тайлбарлавч тийм ч амархан анхаарч сонсох шинжгүй байдаг. Тийм учраас ерөнхийлөгч бидэнд “Гомдлыг нь сонсож өгөх”-ийн чухлыг сургалаа.

“Гомдлыг сонсох” гэдгийн “сонсох” гэсэн үг нь “хүслийг нь анхааралтай сонсох” гэсэн утгатай юм. Сэтгэлээр унаж, гуниж гомдоллохыг нь чих тавин сонсонгоо “Үнэхээр хэцүү байсан байх даа” гэж нөгөө хүнээ чин сэтгэлээсээ өрөвдөж, тэврэн гуниг зовлонг нь өөрийн мэт мэдрэх нь ямар ч мунхагт автсан хүний сэтгэлд том ухаарлыг авчирах нь гарцаагүй.

Энэхүү номлол нь “Турван хор”-ыг ялж дийлэх билиг ухаан болох “Сонсох”-ын чухлыг надад ойлгуулсан бөгөөд заримдаа нөгөө хүнийхээ сэтгэлийг үл анхааран, өөрийн үзлийг нэг талыг барин тулгачихдаг миний хувьд бас нэгэн сэтгэлд хүрсэн сургаал байлаа.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp